|-------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|--|
|       |                                                                                                                                                            |  |                                                                                                                                                     | гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлага, хамралтын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.                                                                |                                                                                                                                                                                                                                                                      | сар бүр хүргүүлэн ажиллаж байна.<br>Дараах мэдээ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн болно.<br>- Сарын мэдээ- 12 удаа<br>- Нийгмийн даатгалын сангийн өглөг, авлагын мэдээ- 12 удаа<br>- Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ -12 удаа<br>- Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан – 2 удаа<br>- Байгууллагын санхүүгийн тайлан - 2 удаа<br>Э-тайлан - 1 удаа тус тус НДЕГазраас ирүүлсэн хуваарийн дагуу хугацаанд нь чанартай гаргаж цахимаар болон цаасаар хүргүүлэн ажилласан.<br>Санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр гаргаж 12 удаа Green EPR системээр илгээсэн. |     |  |
| 2.1.9 | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. |  | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан. | Нийгмийн даатгалын газрын дэргэдэх өмч хамгаалах байнгын зөвлөл нь 2024 онд 1 удаа хуралдаж үндсэн хөрөнгийн элэгдлээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх болон цаашид | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах.<br>-Эзэмшил газар, барилга байгууламж, | А. НДЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн 02/138 албан бичгийн дагуу үндсэн хөрөнгө актлах, данснаас хасах саналыг НДЕГазарт холбогдох бичиг баримтын хамт хүргүүлсэн. Үүнд: Тоног төхөөрөмж 2.3 сая төгрөг, тавилга эд хогшил 0.8 сая төгрөг, барилга 0.9 сая төгрөгийн хөрөнгө байна.<br>Б. ТӨ1-ТӨ11, ТӨХ маягтыг НДЕГазрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дотоод                                                                                                                                                                                                       | 100 |  |

|        |                                 |  |                        |                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |     |  |
|--------|---------------------------------|--|------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|--|
|        |                                 |  |                        | <p>ашиглах боломжгүй, өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг актлах саналыг хэлэлцэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2023 оны хийсэн ажлын гэрээ дүгнэж тус газар нь 94 хувьтай дүгнүүлсэн. Түрээсийн гэрээ байгуулж ажилладаггүй болно.</p> | <p>тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ/ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх. -Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах.</p> | <p>сүлжээнд 2025.04.01-ны өдрийн дотор хугацаанд нь байршуулсан. в. НДГазрын даргын 2025 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн А/15 дугаар тушаалаар эд хөрөнгийн хагас жилийн тооллогыг 4 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгуулан ажилласан. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг НДГазрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/25 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй батлан тооллогын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. г. Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллаж 2025 оны байдлаар “Үндсэн хөрөнгө актлах, данснаас хасах” тухай саналыг хэлэлцэн 1 удаа хуралдсан байна. д. НДЕГ-ын 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/707 албан бичгийн дагуу ТӨБЗГазрын burtgel.gov.mn цахим хуудсанд 2024 оны эд хөрөнгийн хөдөлгөөн, санхүүгийн жилийн эцсийн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 07-ний байршуулсан. е. ТӨБЗГазартай 2024 оны гэрээ дүгнэж 82 хувьтай дүгнүүлсэн, түрээсийн гэрээ байгуулж ажилладаггүй болно.</p> |     |  |
| 2.1.10 | Төсвийн тухай хууль тогтоомжийн |  | Зөрчилгүй дүгнэлт авч, | а) Нийгмийн даатгалын                                                                                                                                                                                                                                                                         | а) Нийгмийн даатгалын сангийн                                                                                                                                                                                                                  | а/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | 100 |  |

|  |                                                                                                                   |  |                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |  |
|--|-------------------------------------------------------------------------------------------------------------------|--|---------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
|  | хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, жилийн эцсийн тайланд аудитын байгууллагаас зөрчилгүй дүгнэлт авах. |  | зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна. | сангийн санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар зөрчилгүй дүгнэлт авсан. б) 2024 оны төрийн аудитын шалгалтаар нийт 26.0 сая төгрөгийн албан шаардлага, 0.3 сая төгрөгийн актын төлбөр зөрчил илэрснийг 100 хувийн биелэлттэй Хэнтий аймаг дахь Төрийн Аудитын газарт хугацаанд нь хүргүүлсэн. | санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар зөрчилгүй дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 60.0 хувь биелүүлэх. | санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул Аймгийн Аудитын газраас <b>өөрчлөлтгүй</b> дүгнэлт авсан болно. б/ Аудитын газраас 1-ээс дээш жилийн насжилттай 131,9 сая төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулах албан шаардлага тавигдсанаас 98,0 сая төгрөг буюу <b>74,30 хувийг</b> барагдуулан ажилласан. Барагдаагүй үлдсэн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагад хариуцагч нас барсан, Улсын бүртгэлийн газраас хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа гарахгүй, эзэн холбогдогчтой болоогүй өв хүлээн аваагүй, Улсын бүртгэлийн хэлтэс нь 2015 онд шимтгэлийн өртэй байхад татан буулгасан хариуцагчгүй зэрэг авлагууд үлдсэн болно. -Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын шалгалтаар <b>Өөрчлөлтгүй</b> |  |
|--|-------------------------------------------------------------------------------------------------------------------|--|---------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|

|        |                                                                                                |  |                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |     |  |
|--------|------------------------------------------------------------------------------------------------|--|----------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|--|
|        |                                                                                                |  |                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                 | дүгнэлт авсан. Аудитаар 1 албан шаардлага, 1 акт тавигдсан бөгөөд <b>100 хувь</b> барагдуулсан биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Төрийн Аудитын газарт цахимаар болон цаасаар хүргүүлсэн байна.                                                                                                                                                       |     |  |
| 2.1.11 | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг цаг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх.             |  | Байцаагч ажилтнуудын хариуцлага өсч, мэдээллийн сангийн мэдээлэл үнэн зөв баталгаатай бүртгэгдсэн байна. | а) Нийгмийн даатгалын сангийн анхан шатны баримт материалыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд үнэн зөв тусгаж, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргах ажлыг зохион байгуулан ажилласан.<br>б) 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн SICOS веб программын ашиглалтын бүрэн бүтэн байдлыг ханган ажиллаж байна. | а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б) Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэх ажлыг зохион байгуулах. | а/ Нийгмийн даатгалын сангийн анхан шатны баримт материалыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд үнэн зөв тусгаж, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргах ажлыг зохион байгуулан ажиллалаа.<br>б/ 2024 оны эцсийн үйлчилгээ буюу нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг хуваарийн дагуу татуулж хөрвүүлэн, тохируулга үйлчилгээг бүрэн хийлгэж баталгаажуулсан. | 100 |  |
| 2.1.12 | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах |  | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.                                           | а) Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны тайлангаар өглөг авлагын тооцоо                                                                                                                                                                                                                                         | а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр                                                                                                                                                             | а/ Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайлангаар өглөг, авлага гараагүй бөгөөд харилцагч байгууллагуудтай өр авлагагүй гэсэн тооцоо нийлсэн актыг улирал бүр                                                                                                                                                                                | 100 |  |

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                               |  |                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                       |                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |     |  |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|--|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                               |  |                                                                                                                                                                                                                      | гараагүй болно.<br>б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангаар гарсан өглөг, авлагын үлдэгдлийг улирал бүр баталгаажуулан ажиллаж байна.      | бүрэн шинэчлэн баталгаажуулах.<br>б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. | нийлж баталгаажуулан ажиллаж хэвшсэн.<br><br>б/ Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангаар гарсан өглөг, авлагын үлдэгдлийг хариуцсан байцаагч, байгууллага болгонтой улирал бүр баталгаажуулан ажиллаж байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |     |  |
| <b>Биелэлт – 1174/12 97.8 %</b>                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                                                                                                                               |  |                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                       |                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |     |  |
| <b>Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт</b>                                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                               |  |                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                       |                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |     |  |
| “Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ: |                                                                                                                               |  |                                                                                                                                                                                                                      |                                                                                                                                                       |                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |     |  |
| 3.1.1                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Нийгмийн даатгалын сан болон үйл ажиллагааны хэрэгжилтэд дээд шатны байгууллагаас ирүүлсэн чиглэлийн дагуу дотоод аудит хийх; |  | Батлагдсан удирдамжийн дагуу дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шалгалтын үр дүнг Хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, баталгаажуулан тайланг Дотоод аудит, мониторингийн газарт хүргүүлсэн байна. | Батлагдсан удирдамжийн дагуу дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж дүнг нийгмийн даатгалын газрын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэн тайлагнасан байна. | Хяналт шалгалтаар тогтоосон төлбөр зөрчил, албан шаардлага, хугацаатай үүрэг даалгавар, бүрэн барагдсан байх.                                                   | Захиргаа хяналтын хэлтэс нь 2025 онд дээд шатны байгууллагаас ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Дотоодын хяналт шалгалтыг тогтмолжуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоох ажлын хүрээнд 2024-2025 онд шинээр тогтоосон 290 тэтгэвэр авагчийн тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгасан. Шалгалтад 17 сумын тэтгэврийн хувийн хэрэг, материал хамрагдаж, 28 тэтгэвэр авагчтай холбоотой 9.9 сая төгрөгийг нөхөн төлүүлэх, 16 тэтгэвэр авагчтай холбоотой 7.2 сая төгрөгийг нөхөн олгохоор, нийт 17.1 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлэн ажилласан.Хяналт | 100 |  |

|  |  |  |  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |  |
|--|--|--|--|--|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
|  |  |  |  |  | <p>шалгалтын хүрээнд гарсан зөрчлийг барагдуулах цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах үүрэг даалгавар өгсөн. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд нөхөн тайлагнасан, цалин, даатгуулагчийн төрлийг өөрчилсөн, устгасан, даатгуулагчийн регистр зэрэг үндсэн мэдээллийг засварласан, нэгтгэсэн байдалд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 54 байгууллагатай холбоотой 118 даатгуулагчийн 166.3 сая төгрөгийн цалин сангаас улсын байцаагчийн акт болон шүүхийн шийдвэрээр нөхөн тайлагнасан мөн даатгуулагчийн цалин, төрлийн залруулгийг 32 байгууллагат хийсэн бөгөөд нотлох баримт материал нь үндэслэлтэй, хуулийн дагуу шийдвэрлэгдсэн байна гэж үзэн тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн. Их, дээд болон коллежийн, түүнчлэн ерөнхий боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын шалгалтад жагсаалтаар ирүүлсэн 3 ажил олгогчийн 1 нь төсвийн байгууллага, 2 нь жолооны курс ажиллуулдаг сургалтын төв тул</p> |  |
|--|--|--|--|--|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                    |  |                                                                                                                                                                                                           |                                                                                                                        |                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |     |  |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|--|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|--|
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |                                                    |  |                                                                                                                                                                                                           |                                                                                                                        |                                                                                                           | шалгалтанд хамрагдаагүй тухай мэдээг хүргүүлэн ажилласан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |     |  |
| 3.1.2                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтэд аудит хийх; |  | Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг баримталсан байна. | 2024.01.01 - 2024.11.30-ны хүртэлх хугацааны Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр дотоод аудит хийсэн. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулсан байна. | Тус газар нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу Нийгмийн даатгалын газрын шилэн дансны хэрэгжилтэд улирал бүр хяналт тавин ажиллаж хийсэн ажлын тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын ДАТГ-т хүргүүлэн ажилладаг. Мөн Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай 03 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны тайлант хугацаанд шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн хяналт шалгалтаар хугацаа хоцроож байршуулсан төлөвт байгаа 3 мэдээлэл байсан ба цаашид дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллахыг үүрэг болгосон. | 100 |  |
| “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ: |                                                    |  |                                                                                                                                                                                                           |                                                                                                                        |                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |     |  |
|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Нийгмийн даатгалын тухай                           |  | Холбогдох хууль                                                                                                                                                                                           | Шалгалт хийж илэрсэн                                                                                                   | Шалгалтын үр дүнг улирал тутамд                                                                           | Нийгмийн даатгалын газар нь 2025 онд хийх хяналт,                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |     |  |

|       |                                                                                                                                                        |  |                                                                                                     |                   |                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |    |  |
